



## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

**АНУ:** Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдсан ба геополитикийн мэдээнээс үүдсэн савлагаанууд ажиглагдсангүй. Шинжээчдийн үзэж байгаагаар, хөрөнгө оруулагчид зах зээлийн ирээдүйг таамаглахаас илүүтэйгээр ашигт ажиллагаа өндөртэй байсан компаниудын хувьцааг сонгон арилжаалж байгаа юм.

Технологийн компаниудыг илүү агуулсан Nasdaq Composite индекс нь зах зээлийн бусад индексүүдээс илүү өсөлттэй байлаа. Харин өндөр зах зээлийн үнэлгээтэй компаниудыг агуулдаг S&P 500 индексийн сагсанд багтах тээврийн салбарын компаниудын хамгийн их өсөлт үзүүлсэн байна. Энэхүү өсөлт нь агаарын тээврийн Southwest Airlines болон American Airlines компаниудын ашигт ажиллагаа өндөр байсантай холбоотой.

Онгоц үйлдвэрлэгч Боинг компани 2018 онд 737 MAX онгоцнуудаа зах зээлээс татсантай холбоотой тус компанийн борлуулалт болон ашиг буурч байсан билээ. Харин энэ долоо хоногт компанийн 3-руирлын тайландаа 737 MAX онгоцнуудын засвар дууссан ба 2019 оны эцсээс өмнө нислэг үйлдэхэд бэлэн болно хэмээн мэдэгдсэнтэй холбоотой компанийн хувьцааны үнэ өндөр өсөлт үзүүллээ. Мөн цахилгаан машин үйлдвэрлэгч Tesla компанийг шинжээчид энэхүү улиралд алдагдалтай ажиллана хэмээн таамаглаж байсан бол шинжээчдийн таамгийг эвдэн Tesla компани ашигтай ажилласан ба үүнтэй холбоотойгоор компанийн хувьцааны ханш тайлан гарсан өдөр 18%-ийн өсөлт үзүүлсэн байна.

**Европ:** Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд компаниудын 3-р улирлын тайлангууд эерэг байсантай холбоотой өсөлттэй байсан ч Brexit-ийн тодорхойгүй байдал болон АНУ болон БНХАУ-ын худалдааны маргаантай холбоотойгоор индексүүдийн өсөлтийг хязгаарлалаа.

Их Британийн фунтийн ханш суларсан ба энэхүү ханшийн сулрал нь Brexit-ийн тодорхойгүй байдалтай холбоотой юм. Европын холбооноос Brexit-ийн хугацааг сунгах оролдлогыг Франц улсын Ерөнхийлөгч ноён Эммануэль Макрон эсэргүүцсэн байна. Ноён Эммануэль Макрон нь эцсийн хугацааг 11-р сарын 31 хүртэл сунгахыг зөвшөөрөх ч Европын холбооноос дараа оны 01-р сарын 30 хүртэл сунгах хүсэлтэй байгаа юм. Эцсийн хугацааг 01-р сарын 30 хүртэл сунгасан тохиолдолд Их Британийн Ерөнхий сайд ноён Борис Жонсон 12-р сарын 12-ны өдөр сонгууль явуулах боломжтой болох ба хэлэлцээрийг шинэ Парламент нь дэмжих магадлалтай болох юм.

**Япон:** Япон улсын хөрөнгийн зах зээл Эзэн хааны титмийн өдөртэй холбоотой Мягмар гарагт хаалттай байсан ч долоо хоногийн эцсийн байдлаар индексүүд өсөлттэй байлаа.

9-р сард Япон улсын экспортын хэмжээ хүлээж байснаар илүү хувиар буурсан байна. Усан хүргэлт өнгөрсөн жилийн тус үеэс 5.2%-аар буурсан гэдгийг Сангийн Яамнаас мэдээлсэн нь энэхүү үзүүлэлтийн буурсан арав дахь сар болж байгаа юм. Бууралтад нөлөөлсөн гол шалтгаан нь Япон улс БНСУ-ын экспортод тавьсан хязгаарлалтаас үүссэн худалдааны маргаан юм. Шинжээчид Япон улсын Төв Банкныг 10-р сарын мөнгөний бодлогын уулзалтаар мөнгөний бодлогыг зөөлрүүлнэ хэмээн үзэж байна.

**БНХАУ:** БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй байлаа. Энэхүү өсөлтийн шалтгаан нь БНХАУ-ын компаниудын 3-р улирлын ашигт ажиллагаа өндөр байсантай мөн БНХАУ-ын Төв Банкнаас зах зээлийн хөрвөх чадварыг ихэсгэхээр мөнгөний нийлүүлэлт хийсэнтэй холбоотой юм.

Өнгөргөч долоо хоногт БНХАУ 1992 оноос хойших хамгийн бага эдийн засгийн өсөлтийг үзүүлсэн ба БНХАУ-ын Төв Банк эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор санхүүгийн системд 250 тэрбум юанийн нийлүүлэлт хийсэн байна.

**Эх сурвалж:** Troweprice.com

### Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	18,126.24	-1.83% ▼
Dow Jones	АНУ	26,958.06	0.70% ▲
S&P 500	АНУ	3,022.55	1.22% ▲
Nasdaq	АНУ	8,243.12	1.90% ▲
S&P/TSX	Канад	16,404.49	0.17% ▲
FTSE 100	Их Британи	7,324.47	2.43% ▲
S&P/ASX 200	Австрали	6,739.20	1.35% ▲
Nikkei 225	Япон	22,799.81	1.37% ▲
Hang Seng	Хонг Конг	26,667.39	-0.20% ▼

### Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	112.63
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	101.68
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	100.75
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	109.42
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	103.83
DBM' 2023	USD	7.250%	104.44
TDBM' 2020	USD	9.375%	102.59
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	97.45

### Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	1.805	-0.05 ▼
Libor 3M	1.928	-0.02 ▼
Libor 6M	1.933	-0.02 ▼
Libor 1YR	1.956	-0.02 ▼
US 2YR Bond	1.622	0.03 ▲
US 3YR Bond	1.619	0.04 ▲
US 5YR Bond	1.624	0.04 ▲
US 10YR Bond	1.800	0.02 ▲

### Валютын ханш /төг/

Валют	2019.10.25	Өөрчлөлт
USD	2,685.97	0.26% ▲
CNY	379.81	0.35% ▲
EUR	2,985.86	0.18% ▲
RUB	41.99	0.24% ▲
KRW	2.29	0.88% ▲
JPY	24.73	0.28% ▲
CAD	2,056.32	0.79% ▲

### Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,504.63	0.98% ▲
Мөнгө /spot/	USD/t oz.	18.04	2.77% ▲
Зэс	USD/lb.	267.55	1.50% ▲
Нүүрс	USD/MT	67.70	-1.60% ▼
WTI газрын тос	USD/bbl.	56.66	5.36% ▲
Brent газрын тос	USD/bbl.	62.02	4.38% ▲

### Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. IX	9.00%
Бодлогын хүү	2019. IX	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. IX	11.12%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. IX	11.37%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. IX	4.95%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. IX	16.91%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. IX	10.76%

**Эх сурвалж:** Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 42 компанийн 761.3 сая төгрөгийн 2,165,146 ширхэг хувьцаа арилжаалагдав.


“Улсын их дэлгүүр” /UID/ компанийн хувьцаа 30.82%-аар буюу хамгийн ихээр өсөж 1,112.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Хөх ган” /HGN/ компанийн хувьцаа 11.11%-аар буурч 8,000.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 2,667 ширхэг үнэт цаас 272.2 сая төгрөгөөр арилжаалагджээ.

10-р сарын 25-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,390.8 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 18,126.24 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.83%-аар буурсан байна.

## MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

## Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

## Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	1,033.5
Зах зээлийн үнэлгээ	2,390,771.2

## Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	18,126.24	-1.83% ▼
MSE I индекс	8,250.37	-1.59% ▼
MSE II индекс	7,388.95	-0.37% ▼

## Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Ард даатгал	44,775	255,559,140
Ард санхүүгийн нэгдэл	54,742	166,678,813
Инвескор ББСБ	354,756	101,556,265
Ард кредит ББСБ	2,908	43,518,944
Таван толгой	9,412	37,179,170

## Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Улсын их дэлгүүр	1,112.00	30.82% ▲
Мерекс	23.00	15.00% ▲
Хөсөг трейд	2,186.00	14.99% ▲
Бэрх уул	600.00	9.09% ▲
Ард кредит ББСБ	75.01	2.50% ▲

## Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Хөх ган	64.00	-11.11% ▼
Техник импорт	8,000.00	-11.11% ▼
Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн	455.03	-8.81% ▼
Женко тур бюро	66.01	-7.03% ▼
Махимпекс	2,228.00	-5.19% ▼

## Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Ард Секюритиз	831,451,461
Мирэ Эссет Секьюритис Монгол	379,139,838
Стандарт Инвестмент	205,703,344
Бумбат-Алтай	121,489,090
Голомт Капитал	96,781,400

## Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	503.54	535,858
Таван толгой	6,290.00	331,264
МИК Холдинг	11,000.00	227,803
Говь	272.00	212,191
Инвескор ББСБ	1,999.00	143,384

## ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-18/07/20-A0275-15.14	804	82,659,240	102,810	102,810	156	15.140%
2	ZGEB-BD-20/06/20-A0260-15.14	1,063	108,823,760	100,970	102,520	156	15.140%
3	ZGEB-BD-27/03/20-A0225-18	800	80,728,000	100,910	100,910	156	18.000%

## НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.06.14-нд олгов
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дютри фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.27-нд олгов
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.05.20-нд олгов
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.17-нд олгов
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.21-нд олгов
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	2019.07.19-нд олгов
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.07.26-нд олгов
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.06.11-нд олгов
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор
32	HRM	Гермес центр ХК	481.3	447.7	93.0%	5.7	2019.08.15	2019.09.02	2019.09.18-нд олгов
33	SUU	Сүү ХК	5,706.4	1,143.4	20.0%	3.3	2019.09.09	2019.04.05	2019.10.24-нд олгов



## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### “Ард санхүүгийн нэгдэл” ХК ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг сонголоо

“Ард санхүүгийн нэгдэл” ХК /MSE: AARD/ хувьцаа эзэмшигчдийн эчнээ санал хураалтаас Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээ шинээр сонголоо.

Энэ удаагийн санал хураалтад саналын эрхтэй хувьцааны 79.11% нь оролцож дараах хүмүүсийг ердийн болон хараат бус гишүүдээр сонгосон гэж компани мэдэгдэв. Үүнд:

1. Ч.Ганхуяг
2. Х.Батхишиг
3. А.Сүхдорж
4. Бруно Е.Рашле
5. О.Одбаяр нар ердийн гишүүнээр
6. П.Батбаяр
7. М.Сэргэлэн
8. Ч.Мөнхбат
9. Жим Андерсон
10. Михаил Зелдович
11. Арнауд Вентура нар хараат бус гишүүдээр сонгогдсон байна.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

### “Ард кредит ББСБ” ХК олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн тайлан ирүүлээ

Монголын хөрөнгийн биржид 2019 онд шинээр үнэт цаасаа бүртгүүлж, олон нийтээс 5.2 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн “Ард Кредит ББСБ” ХК нь татан төвлөрүүлсэн хөрөнгийг 2019 оны 09-р сарын 30-ны өдрийн байдлаар дараах байдлаар зарцуулсан тухай тайлан ирүүлсэн байна. Үүнд:

- Бизнесийн зээл: 2.7 тэрбум төгрөг;
- Хэрэглээний зээл: 612.5 сая төгрөг;
- Шуурхай зээл: 980.0 сая төгрөг;
- Кредит карт: 367.5 сая төгрөг;
- Ард аппликэйшн: 49.0 сая төгрөг;
- Хувьцаа барьцаалсан зээл: 122.5 сая төгрөг.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

### “Лэндмн ББСБ” ХК 2019 оны 3-р улирлын тайлангаа нийтэлжээ.

Санхүүгийн үйл ажиллагаа явуулдаг “Лэндмн ББСБ” ХК /MSE: LEND/ 2019 оны 3-р улирлын санхүү болон үйл ажиллагааны тайлангуудаа өөрийн цахим хуудсанд нийтэлжээ.

“Лэндмн ББСБ” ХК нь 2019 оны 9-р сарын 30-ны байдлаар 9.7 тэрбум төгрөгийн санхүүгийн цэвэр орлого, 3.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Тус компанийн хувьцаа Монголын Хөрөнгийн Биржийн 1-р самбарт бүртгэлтэй ба 2019 оны 10-р сарын 25-ны өдрийн байдлаар хаалтын ханш 45.06 төгрөг байна.

**Эх сурвалж:** Ти Ди Би Капитал ҮЦК

### “Ард кредит ББСБ” ХК 2019 оны 3-р улирлын тайлангаа нийтэлжээ.

Санхүүгийн үйл ажиллагаа явуулдаг “Ард кредит ББСБ” ХК /MSE: ADB/ 2019 оны 3-р улирлын санхүү болон үйл ажиллагааны тайлангуудаа Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсанд нийтэлжээ.

“Ард кредит ББСБ” ХК нь 2019 оны 9-р сарын 30-ны байдлаар 3.7 тэрбум төгрөгийн нийт үйл ажиллагааны орлоготой, 1.6 тэрбум сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Тус компанийн хувьцаа Монголын Хөрөнгийн Биржийн 2-р самбарт бүртгэлтэй ба 2019 оны 10-р сарын 25-ны өдрийн байдлаар 75.1 төгрөгийн хаалтын ханштай байгаа юм.

**Эх сурвалж:** Ти Ди Би Капитал ҮЦК

### “Мандал даатгал” ХК 2019 оны 3-р улирлын тайлангаа нийтэлжээ.

Албан журмын нийгмийн даатгалаас бусад даатгал, давхар даатгал, тэтгэврийн санхүүжилтын үйл ажиллагаа явуулдаг “Мандал даатгал” ХК /MSE: MNDL/ 2019 оны 3-р улирлын санхүүгийн тайлангуудаа Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсанд нийтэлжээ.

“Мандал даатгал” ХК нь 2019 оны 9-р сарын 30-ны байдлаар 22.9 тэрбум төгрөгийн орлого, 4.6 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай байсан ба үнэт цаасны дахин үнэлгээний нэмэгдэл нь -342.9 сая төгрөг хүрсэн байна.

Тус компанийн хувьцаа Монголын Хөрөнгийн Биржийн 1-р самбарт бүртгэлтэй ба 2019 оны 10-р сарын 25-ны өдрийн байдлаар хаалтын ханш 4,900.0 төгрөг байна.

**Эх сурвалж:** Ти Ди Би Капитал ҮЦК

### “Сүү” ХК-ийн 2018 оны ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршууллаа

“Сүү” ХК-ийн 2018 оны ногдол ашиг болох нэгж хувьцаанд хуваарилах 3.33 төгрөгөөс албан татвар суутгасан дүн 3.00 төгрөгийн ногдол ашгийг 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдөр хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршууллаа.

**Эх сурвалж:** Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

### “Ган хийц” ХК-ийн 2018 оны ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршууллаа

“Ган хийц” ХК-ийн 2018 оны ногдол ашиг болох нэгж хувьцаанд хуваарилах 50.00 төгрөгөөс албан татвар суутгасан дүн 45.00 төгрөгийн ногдол ашгийг 2019 оны 10 дугаар сарын 21-ний өдөр хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршууллаа.

**Эх сурвалж:** Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

## ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### “Оюу толгой” компани 2019 оны 3-р улирлын гүйцэтгэлийн тайлангаа танилцууллаа

2019 оны 3-р улиралд “Оюу толгой” компанийн 200,000 хүн/цаг тутамд ногдох гэмтэл бэртлийн давтамж 0.18 байв. Энэ хугацаанд аюулгүй ажиллагаа тэргүүлэх чиглэл хэвээр байхын зэрэгцээ аюулгүй ажиллагааны сайн гүйцэтгэлээ бататган ажиллалаа. Аюулгүй ажиллагааны соёлоо олон нийтэд түгээн таниулах зорилгоор Цагдаагийн Ерөнхий Газартай хамтран 280 сая гаруй төгрөгөөр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах болон орон нутгийн замд хяналтын систем суурилуулах зэрэг чиглэлээр нөлөөллийн аян зохион байгуулж байна. Түүнчлэн, энэ сарын эхэнд бид Мэргэшсэн Хөдөлмөрийн Аюулгүй Байдал, Эрүүл Ахуйн Мэргэжилтнүүдийн Холбоотой (МОШПА) хамтран “Нэн түрүүнд ХАБ - 2019” бага хурлыг зохион байгууллаа.

“Оюу толгой” компани 2019 оны эхний гурван улиралд 764 ханган нийлүүлэгчтэй хамтран ажилласны 524 нь үндэсний компани бөгөөд үйл ажиллагааны худалдан авалтын 76 хувийг эдгээр компанид зарцуулав. 2010 оноос 2019 оны III улирал хүртэлх хугацаанд үндэсний худалдан авалтад гурван тэрбум ам.доллар зарцуулсан бол мөн хугацаанд Өмнөговь аймгийн ханган нийлүүлэгчдээс авсан бараа, үйлчилгээ худалдан авалтдаа 523 сая ам.доллар зарцуулсан байна. “Оюу толгой” компани ирэх гурван жилийн хугацаанд олон улсын стандартын шаардлага хангасан хөдөлмөр хамгааллын гутлыг дотоодоосоо худалдан авахаар үндэсний гутлын үйлдвэр болох “Хос-Аз” ХХК-тай 2.7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий ханган нийлүүлэлтийн гэрээ байгууллаа. Өмнөговь аймгийн Манлай сумд Оюу толгойн уурхайд баяжмалын уут болон нэг удаагийн хамгаалалтын хувцас нийлүүлэх хоёр үйлдвэр нээлтээ хийснээр тус сумд нийт 64 ажлын байр шинээр бий боллоо.

### Гүний уурхайн төслийн шинэчилсэн мэдээлэл

Оюу толгойн гүний уурхайн 2-р босоо амны үйлчилгээ болон үйлдвэрлэлийн өргүүрийн ган татлага суурилуулах ажил дууслаа. III улиралд амжилттай дууссан бусад бүтээн байгуулалтуудыг дурдвал дулаан хангамжийн холбогдох бүтцүүд, 2-р босоо амны хацарт бутлуурын систем болон чулуулаг тээвэрлэх дамжуулга нар болно. III улиралд гүний уурхайн хөндлөн малталт хурдацтай урагшлав. Тухайлбал 9-р сард нийт 1,385 метр хөндлөн малталт хийсэн. Мөн 2019 оны 7-р сарын 15-нд зарлаж байсанчлан одоогоор ашиглаж буй зураг төслийн дагуу гүний уурхайг үргэлжлүүлэхэд хөрс чулуулгийн байдал тохиромжгүй, улмаар эрсдэл үүсэх нь геотехникийн нэмэлт нарийвчилсан мэдээллээс тодорхой байгаа тул төслийг амжилттай дуусгахын тулд уурхайн зураг төслийн хэд хэдэн хувилбарыг эргэн авч үзэх хэрэгтэй болсон. Энэ хугацаанд гүний уурхайн бүтээн байгуулалт тасралтгүй үргэлжлэх бөгөөд гүний уурхайн төслийг гүйцэтгэх зардал, хуваарийн эцсийн тооцоолол болох нарийвчилсан үнэлгээг тодорхой болсон үед мэдээлэх болно.

### 2019 оны 3-р улирлын үйлдвэрлэлийн тайлан

III улирлын үйл ажиллагааны гүйцэтгэл сайн байсан ч баяжуулах үйлдвэрийн түр зогсолт буюу төлөвлөгөөт засвар үйлчилгээг 10-р сараас 9-р сард шилжүүлсэн болон олборлолтын 4В үе шатны хатуулаг өндөртэй хүдрийг төлөвлөснөөс илүү ашигласан зэрэг нь нөлөөлсөн.

-28,446 тонн зэс олборлосон нь 2018 оны III улиралтай харьцуулахад 27.8 хувиар бага

-25,607 унци алт олборлосон нь 2018 оны III улиралтай харьцуулахад 66.8 хувиар бага

-Боловсруулсан хүдрийн хэмжээ өмнөх оны мөн үеэс дөрвөн хувиар илүү, харин өмнөх буюу II улиралтай харьцуулахад 3.4 хувиар буурсан

-2019 оны зэс, алтны үйлдвэрлэлийн төлөвлөгөөгөө биелүүлэхээр ажиллаж байна

Урьдчилан таамаглаж байсанчлан, олборлолтын 4А үе шатнаас агуулга багатай 4В үе шатанд шилжиж, хуримтлуулсан хүдрийн овоолгыг ашигласантай холбоотойгоор:

-Зэсийн агуулга 2019 оны II улиралд 0.46 байсан бол тайлант улиралд 0.37 болсон

-Алтны агуулга 2019 оны II улиралд 0.31 байсан бол 0.14 болсон

-Үйлдвэрлэсэн баяжмалын хэмжээ 2019 оны II улиралтай харьцуулахад 27.2 хувиар буурсан

-Үйлдвэрлэсэн баяжмал дахь зэсийн хэмжээ 2019 оны II улиралтай харьцуулахад 27.4 хувиар буурсан

-Үйлдвэрлэсэн баяжмал дахь алтны хэмжээ 2019 оны II улиралтай харьцуулахад 64.3 хувиар буурсан

**Эх сурвалж:** OT.mn

### “Эрдэнэ ресурс девелопмент корпораци” ХК нь Баян Хөндий алтны төслийн урьдчилсан ТЭЗҮ-ийн эерэг үр дүнг танилцууллаа

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD | MSE:ERDN) (цаашид “Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани” гэх) нь Монгол улсын баруун өмнөд хэсэгт орших өөрийн 100% эзэмшлийн өндөр агуулга бүхий илээр олборлох боломжтой Хөндий Алтны Төслийн хараат бус техникийн тайланг танилцуулж байна. Энэхүү техникийн тайланд Баян Хөндий ордын (“Bayan Khundii”) урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл (“урьдчилсан ТЭЗҮ”; PFS) болон Баян Хөндийгөөс 16 км зайд зайд орших Алтан Нар ордын (“Altan Nar”) шинэчилсэн анхан шатны эдийн засгийн тооцоолол (“АШЭЗТ”) орсон болно. Түүнээс гадна тайланд Баян Хөндийн шинэчлэгдсэн ашигт малтмалын баялаг болон нөөцийн мэдээлэл багтсан. Техникийн тайланг Tetra Tech Inc (“Tetra Tech”) NI 43-101 эрдсийн нөөцийн тайлагналын стандартын (“NI 43-101”) дагуу боловсруулсан. NI 43-101 удирдамжийн дагуу гүйцэтгэсэн Техникийн тайланг 45 хоногийн дотор SEDAR-т бүртгүүлнэ

**Эх сурвалж:** Erdene.com

## МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдалыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.